



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/156


Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дах заалт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Америкийн Нэгдсэн Улсын Гамшгийн болон хүмүүнлэг туслалцааны олон улсын байгууллага "Самаританс Пурс" хооронд 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан "Монгол Улс дах хүүхдийн зүрх төсөл" харилцан ойлголцол, хамтын ажиллагааны хэлцэл бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.


САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080632

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 04 сарын 05-ны өдрийн  
А/156 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Жон Роберт Боковен John Robert Bockoven	Америкийн Нэгдсэн Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Америкийн Нэгдсэн Улсын Гамшгийн болон хүмүүнлэг туслалцааны Олон улсын байгууллага "Самаританс Пурс"	ГЭ0002215	Хүүхдийн зүрх судлал	Эмчлэх	2019.04.08-2019.04.10 /3 хоног/